

Монголчуудын байгаль хамгаалах арга ухааны уламжлал, шинэчлэл, хэрэглээ

Ц.Пүрэвдорж*, Ц.Буянжаргал

МУБИС, Архангай аймаг дахь Багшийн сургууль, Байгалийн ухааны тэнхимийн

Хураангуй

Монголчууд түүхэндээ байгаль орчноо хайрлан хамгаалах олон янзын арга ухааныг нүүдэлчин ахуй амьдралынхаа туршлагаас буй болгож түүнийгээ олон зууны турш хүрээлэн буй байгаль орчныхоо экологийн тэнцвэрт байдлыг хангах иш үндэс, хууль дүрэм болгон даган мөрдөж хойч үедээ өвлүүлэн ирсэн бөгөөд энэ нь байгаль орчныг хамгаалах сэтгэлгээг хувь хүнд төлөвшүүлэх хүмүүжлийн өвөрмөц арга болж монголын хүн амын ихэнх хэсгийн дотор эдүгээг хүртэл уламжлагдан ирсэн нь бүх нийтэд экологийн боловсрол, хүмүүжил олгох төрийн бодлогын уламжлалт чиг хандлагын үндэс суурь нь болж байна.

Гэвч байгаль орчноо хайрлан хамгаалах энэхүү уламжлалт тогтолцооны хэв шинж техник технологийн хурдацтай хөгжлийн эрин үед хүний буруутай үйл ажиллагааны сөрөг хүчин зүйлсийн нөлөөгөөр мартагдах хандлагатай болж үүнийгээ дагаад байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахад хүрч байгаа нь зөвхөн монгол орны төдийгүй дэлхий нийтийн анхаарлын төвд тулгамдаж буй асуудал болж байгаа нь тодорхой байдаг. Иймээс улс орон бүр байгаль орчноо хамгаалсаар ирсэн өөр өөрийн өвөрмөц онцлог бүхий арга туршлагыг түгээн дэлгэрүүлж, иргэн бүрд экологийн зөв боловсролыг тодорхой системтэйгээр эзэмшүүлэх нь чухал юм.

Бид энэхүү өгүүлэлдээ байгаль хамгаалах монгол арга ухааны уламжлал, түүний хэрэглээ, шинэчлэлийн бодлогыг нийгмийн ихэнх хэсгийг бүрдүүлж буй залуучуудын экологийн мэдлэг, боловсролын түвшний байдалд тулгуурлан судлан, цаашдын чиг хандлага, арга замыг тодорхойлохыг зорилгоо.

Түлхүүр үг

Экологийн боловсрол, залуу үе, хэрэглээ, байгалийн тэнцвэр, иргэний үүрэг, хариуцлага, арга туршлага

Удиртгал

Иргэн бүр экологийн боловсролын үнэ цэнийг ухаарч, хүрээлэн буй байгаль орчноо хайрлан хамгаалах сэтгэлтэй байх, байгаль орчноо хамгаалж ирсэн монгол арга ухааны уламжлалыг үр хойчдоо сэргээн өвлүүлдэг байх, түүний хэрэглээ өнөөгийн нийгэмд хэр биеллээ олж буй, цаашид яах ёстой вэ? гэдгийг тодорхойлох зорилгоор судалгааны ажлын материал цуглуулан задлан шинжилж, дүгнэлт гаргалаа. Энэхүү судалгааны ажилдаа бид дараах судалгааны аргуудыг ашиглав.

- Санал асуулгын аргыг ашиглан баримт материал цуглуулан задлан шинжлэх
- Аналогий хийх
- Агуулгыг нэгтгэн дүгнэлт гаргах

Байгаль орчноо хайрлан хамгаалж ирсэн монголчуудын зан үйл, арга ухааны талаарх судалгаа нь олон эрдэмтдийн судлагдахууны гол сэдвийн нэг болсоор ирсэн төдийгүй дэлхий нийтэд экологийн тэнцвэрт байдал алдагдаж буй орчин үеийн шийдвэрлэх чухал асуудлын нэг болж байна. “Аль ч үндэстэн угсаатанд өөрийн

хэл соёл, ёс заншил, шашин шүтлэг байдаг бөгөөд харин эрт галавын үеэс эх байгалийнхаа ааш араншингаар төрж, түүнийгээ тахиж шүтсэн, хайрлаж хамгаалсан сэтгэлгээ нь төстэй юм. Гэвч хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад тэрхүү сэтгэлгээ нь өөр өөр болж, улмаар зан үйлийн өвөрмөц цогц соёл болон төлөвшсөн ч байдаг. Тийм өвөрмөц соёлтой ард түмний нэг нь Монголчууд юм” (Чоймаа, 2009, х.17)

“Байгаль орчныг хамгаалах” гэдэг ухагдахуун нь монголчуудын хувьд, түүнийг гадны ямар нэгэн хүч нөлөөнөөс халхалж хаацайлахын нэр бус, эвдрэл доройтолд орсных нь дараа нөхөн сэргээх арга замыг сүвэгчлэхийн ч нэр бус, харин тэрхүү болзошгүй доройтлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчинтойгоо ухаалгаар зохицон амьдрах, газар дэлхийгээ ижийтэйгээ зүйрлэн, хүндэтгэн дээдлэх, түүнд хүмүүнлэг сэтгэлээр хандан, амьтан ургамлыг нь энэрэн хайрлах экологийн өндөр ёс зүйтэй байж, нөөц баялгийг нь ариглан гамнах явдал юм хэмээн үзсээр иржээ.

Монголчуудын хувьд өвөг дээдсээс уламжлагдан ирсэн байгаль орчныг хайрлах,

* ✉ purevdorj.ts@msue.edu.mn

хамгаалах талаарх олон зууны баялаг уламжлал бий. Тэд уул ус, ургамал амьтнаа бүхнээс илүү мэддэг байсан ба тэдний амьдралын хэв маяг, аж төрөх ёс нь эрхэлж буй мал ахуйгаасаа хамаарч, эрхэлж буй мал ахуй нь байгаль, цаг уур, хөрст шорооноосоо хамаарч, тэрнээр гээд хүнтөрөлхтөнд нөлөөлдөг нарийн нандин эргэх холбоогоор холбогдож байдаг. “Өнөөдөр техникийн болон гар аргаар алт олборлогчид 10 гаруй аймгийн нутаг дэвсгэрийн 130-аад цэгт хуримтлагдсан мөнгөн ус, цианитаар бохирдсон 200 гаруй мянган тонн хаягдал, 53.2 га талбай бохирдсон нь тогтоогдоод байна” гэжээ (Пүрэвбат, 2009, х.31). Эдгээрээр мал амьтан ундаалж, түүгээр хүмүүс бид өөрсдөө хооллоод байгаа гэдгээ ухаарах нь зүй.

“... Говийн тэр сайхан зулай цагаан уулын оргил тэргүүнд хангайн шинж бүрдэж, зун, намар, өвөл, хаварт ээлжилдэг байж л дээ, гэвч одоо байгаль, цаг агаарын хувирлаас болж, байдал төрх нь их л өөрчлөгджээ.” найраглалын хэсгээс доктор (ScD), профессор Б.Пүрэв-Очир банг эш татаж “Сэгс цагаан богд” уу, аль эсвэл “Сэгсэг цагаан богд” уу?! Лавайд бичдэг цуврал өгүүлэлдээ бичсэн байдаг юм. Энэ эшлэлийг ухааж ойлгоход хэд хэдэн санааг гаргасан мэт. “Говийн тэр сайхан зулай цагаан уулын оргил тэргүүнд хангайн шинж бүрдэж,...” гэдгээс харахад ухаант монгол өвөг дээдэс минь говийг хангай болон баяжтал нь сэргээж, хайрлаж чаддаг ард түмэн байсан байхад өнөө үеийнхэн уул усаа ухааж иддэг болсноос үүдэж говийг хангай болгох нь бүү хэл, хангайг говь болгон цөлжүүлж байгаа хэрэг.

Ийнхүү эрдэмтэн судлаачдын судалгааны бүтээлүүдийг судлан агуулгыг дүгнэхэд монголчууд бидний байгаль орчинтой харьцах зан заншлын уламжлалыг хэд хэдэн хэсэгт хувааж үздэг байна. Үүнд:

Байгалиа энэрэн хүндэтгэж ирсэн уламжлал
Хорио цээрлэлийн уламжлал
Сургаал номлолын уламжлал
Сүсэг бишрэлийн уламжлал
Ажиглалт танин мэдэхүйн уламжлал
Түүхэн уламжлал зэрэг болно.

Жишээлбэл, байгалиа энэрэн хүндэтгэж ирсэн уламжлалын дотор л гэхэд ан амьтны үржих, төлжих, үс арьс, тарга хүч гүйцэх цаг хугацааг нарийн танин мэдэж, зөв сонгон авч ан ав хийдэг, ангийн мах, арьс зэрэг олзоороо туйлаас хүндэтгэн, ариглан хэрэглэдэг байж. Олноороо ан гөрөөнд мордохдоо хүндэтгэлийн ёслол үйлдэл хийдэг дэг жаягтай байсан ба түүнийг зөрчих ахул зан заншлын төдийгүй хууль цаазын цээрлэл хүлээдэг байжээ. Мөн мод, усандаа хандаж харьцах зан үйл нь байгалиа энэрэн хүндэтгэж

ирсэн уламжлалын нэг хэсэг юм. Тухайлбал, Монголын говь цөлийн хэсэгт нутагладаг ардууд заг, хайлаас, сухай модыг эрхэмлэн хүндэтгэдэг байсан бол хангай нутгийнхан бургас, хус, хуш, арц ганга, яргай зэргийг илүү хүндэтгэн хайрладаг байжээ. Байгалийг энэрэн хүндэтгэх ёс заншлын дотор уул, усаа өргөн хүндэтгэсэн, зүйрлэн дүйцүүлсэн нэрээр нэрлэх уламжлал ч бас ердийн хэрэг байсангүй. Монголчууд Богд хан, Хустай хан, Онон хатан эжий, Хатан Туул, Алтан-Овоо, Хан-Хөхий, Булган уул хэмээн зарим нутгаа өргөмжлөлийн нэрээр нэрлэх заншил түгээмэл байжээ. Түүнчлэн уул, усны оноосон нэрийг дэргэд нь буюу ойр орчимд нь хэлдэггүй “өндөр хайрхан”, “алтай хангай”, “далай ээж”, “буурал даваа” гэх мэтээр төлөөлүүлэн ярилцдаг байсан нь мөн л байгальд элэг сэтгэлтэй хандаж ирсэн бас нэг ухааны илрэл ажээ.

Монголчуудын байгаль дэлхийгээ хайрлаж ирсэн түүхэн уламжлал, түүнийгээ үр хойчдоо дагалдуулан сургаж ирсэн нь ердийн нэгэн ёс заншил төдий бус, байгаль нь хүний амьдрал, оюун санааны мөнхийн эх сурвалж байж, түүнийг түшиж аж төрөх, хүний гоо сайхны таашаал байгалиас бий болж түүнд уяран татагдах мэдрэмж, сэтгэлгээг төрүүлж, тийм ухаан суулгах, хүмүүжүүлэх, танин мэдүүлэх зохицолдоог бүрдүүлж өгдөг байсан байна. Энэ утгаараа нийгмийн олон талт амьдралын дотроос байгалийг хайрлан хамгаалах сайн сайхан үйлсийн төлөө хүн бүрд сэрэх, санах, эрэх хайх, бүтээн бий болгох тийм хөдөлмөр зүтгэлийг сонгон олж авах ухаарлыг төлөвшүүлсээр иржээ. Тухайлбал:

“Халх журам” хуульд:

- Улс дунд түймэр шатваас аль ойрх улс зартай заргүй унтраа. Зар сонсож байж ноён хүн эс мордвоос морь ав, сайдаас үхэр ав, энгийн улсаас хонь ав.
- Хэн хүн таарсан нутгийнхаа галыг унтраа, эс унтрааваас шүдлэн морь авч бай гэх зэргээр ерөнхийлсөн байдлаар бус тун нарийвчлан нэгд нэгэнгүй зааж өгсөн байдаг.

Ерөнхийлж хэлбэл байгаль хамгаалах зан заншлын уламжлал бол нүүдэлчдийн оюун ухаан, дадал заншил, ёс суртахууны үнэт бүтээл учраас түүнийг цаашид нарийвчлан судлах, арга ухаанд гүнзгий суралцах, амьдралд хэрэгжүүлэн хэрэглэх нь шинжлэх ухаан, практикийн нэг тулгамдсан асуудал гэж үзэж болно.


Бидний яриад байдаг дэлхий нийтийн техник технологийн хурдацтай хөгжлийн буруугаас үүсээд буй байгаль орчны доройтол, экологийн тэнцвэртэй байдлын алдагдалд юу нөлөөлж буйг,

өнөөдөр залуу үеийнхэн минь өвөг дээдсийнхээ байгалиа хамгаалж ирсэн уламжлалт зан үйл, ёс заншлаас хэрхэн суралцаж буйтай танилцах, байгаль орчныг хамгаалах иргэний үүрэг, чиг хандлагыг судлах зорилгоор Архангай аймгийн Эрдэнэбулган, Их тамир, Тариат, Эрдэнэмандал, Чулуут сумдын сэхээтэн, ажилчин, малчдын төлөөлөл болсон нийт 150 залуусаас судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэхийг зорилоо.

Судалгааны хэсэг

Зураг 1


Байгаль орчны доройтолд нөлөөлж буй хүчин зүйлс



Диаграммаас харахад судалгаанд оролцогчид нь байгаль орчны доройтолд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг техник, технологийн хөгжил, хүний буруутай үйл ажиллагаа, уламжлалт зан үйл, нийгэм эдийн засгийн тогтворгүй байдал юм хэмээн гаргаж ирсэн байна. Үүнээс ихэнх хувь буюу 37 хувь нь уламжлалт зан үйл мартагдаж буй, түүний хэрэглээ багассантай холбоотой гэж үзжээ. Энд технологийн хөгжил сөрөг хүчин зүйл үзүүлж байгаа гэж үзсэн хэдий ч 17 хувь нь л ийн хариулжээ. Харвардын их сургуулийн судлаач, физикч Алекс Виспер-Гросын хийсэн тооцоогоор “Google”-ээс 2 мэдээлэл авах хугацаанд компьютерээс данх ус буцалгах хэмжээний нүүрстөрөгчийн хий ялгардаг байна. Мөн зах зээлд борлуулж байгаа бүх төрлийн зай хорт бодис ялгаруулдаг ба зүй бусаар хаясан зай нь хөрс, агаарыг ихээр бохирдуулж, тэсэрч, дэлбэрвэл хорт хийнд нь хүн амиа алдах аюултай юм гэснийг судалгаагаар илрүүлсэн байдгийг санахад илүүдэх юун.

Зураг 2


Уламжлалт зан үйл, уламжлалт аргуудын талаарх залуу үеийнхний мэдлэг.



Энэхүү судалгаанаас жишээлэн дурдвал Эрдэнэбулган сумын залуучууд сүсэг бишрэлийн уламжлалын талаар бусдаасаа арай илүү мэдлэгтэй харагдаж байгаа хэдий ч энэ нь угтаа судалгаанд оролцогчдын дөнгөж 12 хувь нь л ийнхүү хариулсан билээ. Иймд байгаль орчноо хайрлан хамгаалсаар ирсэн уламжлалт зан үйл, арга ухааны талаарх мэдлэг хомс. Хэдийгээр судалгаанд хамрагчдын дийлэнх хувь нь хорио цээр болон сүсэг бишрэлийн уламжлалыг мэдэж байгаа ч түүнийг амьдрал үйл ажиллагаандаа хэрэглэх хандлага, хойч үедээ эзэмшүүлэх арга ухаан, идэвх сул байна гэсэн дүгнэлтийг бид гаргаж байгаа юм.

Зураг 3

Байгалийг хайрлах арга ухааныг эзэмшүүлэхийн тулд ямар нэгэн ажил зохион байгуулдаг эсэх



Судалгаанд оролцогчдын 36.6 хувь нь тодорхой ажлуудыг зохион байгуулдаг гэсэн байхад 63.3 хувь нь зохион байгуулж үзээгүй гэж хариулснаас харахад уламжлалт зан үйл өнөөдөр үндсэндээ алдагдаж, энэ талаар дорвитой ажил хийгдэхгүй байгаа, мөн тэдэнд зориулсан сургалт, сурталчилгааг зохион байгуулах шаардлагатай байгаа нь тодорхой харагдаж байна.

Судалгааны үр дүн

Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл монголчуудын эртнээс байгаль орчноо, танин мэдэж, түүнийг хайрлан хамгаалсаар ирсэн уламжлалт зан үйлийн хэрэглээ нь өнөө үед хэрэгжихгүй байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан субъектүүдийн мэдлэг, чадвар, хэрэглээ, хандлага дараах байдлаар илэрч байна. Үүнд: Ан амьтан, уул ус, ургамал модыг хайрлан хамгаалах зан үйлийн мэдлэг судалгаанд хамрагчдын 50 хүрэхгүй хувийг эзэлж байгаа нь энэ талаарх мэдлэг, чадвар хандлагыг бага наснаас нь, мөн залуу үед заан сургах, хэрэглээ болгон хэвшүүлэх практик дадлага болгох ажлууд дутагдалтай байна.

Тухайлбал, жил бүр мод тарьдаг ч түүнийгээ арчлан тордож, ургуулах ажил хийдэггүй, мод суулгасан газраа эргэж очиж хардаггүй зэрэг нь үүний нэгэн жишээ юм.

Байгаль орчноо хайрлан хамгаалсаар ирсэн уламжлалт зан үйлийн арга ухааныг бага, дунд, ахлах ангиас эхлээд бүх шатны боловсролын байгууллагын хичээлийн сургалтын хөтөлбөрт тодорхой тусгах хэрэгтэй гэж үзэж байна. Тухайлбал, Е.Батчулуун, Г.Юмчмаа, Ц.Сэр-Од, Ц.Цэндсүрэн, Л.Одмандах нарын Газарзүй VIII сурах бичгийн “Байгалийн бүс, байгаль хамгаалал” бүлэг сэдвийн (2017, х.86)-д байгаль хамгаалах арга замуудад уламжлалт зан үйлийн талаарх асуудлыг тодорхой тусгасан байдаг шиг.

Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй уул уурхайн үйлдвэрлэл, бүх шатны албан байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн байгаль орчинтой харьцах хандлага, үйл ажиллагаанд дээрх уламжлалт зан үйл, арга ухааны хэрэглээг хэвшил болгон мөрдүүлэх,

Монголчуудын байгаль орчныг хайрлан хамгаалах уламжлалт зан үйлийг төрийн зүгээс анхаарч байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах үйлст бүх нийтээр дагаж мөрдөх дүрэм журам болгон мөрдүүлэх,

Байгаль хамгаалах үйл ажиллагаанд уламжлал, шинэчлэлийн аргыг хослуулан хэрэглэх шаардлага зүй ёсоор гарч байгаад анхаарлаа хандуулах.

Дүгнэлт

Монголчуудын байгаль орчноо хайрлан хамгаалсаар ирсэн арга ухаан нь тэдний нүүдэлчин ахуй амьдрал, соёлтой нягт холбоотой байсаар ирсэн бөгөөд энэхүү түүхэн уламжлалт ёс, зан үйлийн хэрэглээ нь шинжлэх ухаан, технологийн өндөр хөгжил бүхий эрин үед хүний буруутай үйл ажиллагааны үр дүнд буй болж байгаа экологийн тэнцвэрт байдлын алдагдлыг бууруулахгүй байх арга хэмжээнүүдийг зохион байгуулахгүй байна.

Монголчууд байгаль орчинтойгоо аядуу зөөлөн харьцаж, зохицож амьдарч ирсэн дээрх уламжлалууд өнөө үед алдагдан, хэрэглээний хүрээ нь хязгаарлагдмал болж байгаа нь судалгааны явцаас тодорхой болж байна. Уламжлал шинэчлэлийн бодлогыг хослуулан хэрэглэвээс байгаль хамгаалах ажил үйлст ахиц гарахын зэрэгцээ экологийн боловсролыг монгол арга ухаанаар эзэмшүүлэх үндэс болох арга зам нээгдэх юм.

“Уламжлалаа өгүүлэхийн хамт өнөө цаг үеэ бид харж, ухаарах тухайд хэлэх үг бас буй. Дэлхий

ертөнц, хүн төрөлхтний ахуй байдал тун ч их хувьсч байна. Энэхүү их хувьсал, өөрчлөлтийг үйлдэгч эзэн нь хүн бид билээ. Шинжлэх ухааны гайхамшигт ололт, технологийн их хурдыг бид үгүйсгэхгүй ч, эх байгаль дэлхийгээсээ эхлээд эрдэнэт хүмүүний сэтгэлийг хүртэл гайтуулах болов.” хэмээн эрдэмтэн Ш.Чоймаа бичсэн буйг санахад илүүдэхгүй юм.

Эцэст нь хэлэхэд өвөг дээдэс маань эртнээс үр хүүхэд, хойч үедээ байгалиа хамгаалах арга ухааныг нүүдэлчин, малч амьдралынхаа арга ухаанаас буй болгож түүнийгээ насан туршийнх нь зөв амьдралын баталгаа болгож дагаж мөрдүүлсээр ирсэн тэр зан үйлүүд өнөөдөр үндсэндээ алдагдаж, энэ талаар дорвитой ажил хийгдэхгүй байгаа, мөн тэдэнд зориулсан сургалт, сурталчилгааг болон нөхөн сэргээлт зохион байгуулах шаардлагатай байгаа нь ч тодорхой харагдаж байна.

Ашигласан материал

- Батчулуун, Е., Юмчмаа, Г., бусад. (2017). Газарзүй VIII. Улаанбаатар
- Болд, Ш. (2009). Монголчуудын эрүүл амьдрах ухаан. Улаанбаатар: Мөнхийн үсэг Групп
- Бира, Н., Өлзийсайхан, Ж. (2006). Экологи, Байгаль хамгаалал. Улаанбаатар
- Өлзийсайхан, Ж. (2001). Ардын сурган хүмүүжүүлэх зарим асуудал. Улаанбаатар
- Пүрэв-Очир, Б.(2012). “Сэгс цагаан богд” уу, аль эсвэл “Сэгсэг цагаан богд” уу?! (Монгол газар усны нэгэн нэрийн учир) Цуврал-9. Лавай, ЭШБ VIII.
- Пүрэвбат, Г. (2009). Ирээдүйг эш үзүүлсэн бошгууд. Улаанбаатар
- Пүрэвбат, Г. (2010). Эцэг эхийн ачлалыг хариулах гэгээн сургаал. Улаанбаатар
- Рэгзэндорж, Р., Ганзориг, Р. (2008). Монгол ёс заншил. Улаанбаатар
- Санжид, Ж. (1988). Гаднаас гал гуйдаггүй Монголчуудын байгаль хамгаалах зан үйлээс. Улаанбаатар
- Саранчимэг, Ж. (2013). Сургамжит өгүүллэгүүд. Улаанбаатар
- https://prezi.com/q4qv_op_pvww/presentation/
- <http://www.ncf.mn/index.php/site/knowingmore/2>

Mongolians' traditions and innovations of ways to keep nature

Ts.Purevdorj, Ts.Buyanjargal
Mongolian National University of Education
Arkhangai Teacher's School, Natural Sciences Department

Abstract

The paper presents the history and many ways of keeping nature and its environment that were originally created by Mongolian nomadic people. Mongolians have followed these ways for many centuries using them as the basis and laws to keep the ecological equity of nature. It became one of the traditional ways to build a private person who loves nature and the fundament of traditional tendency of the state policy that makes the public get ecologically educated and disciplined. However, this traditional style of keeping nature tends to be forgotten under the influence of people's negative attitudes towards nature and their wrongdoing activities, so the nature equity has been lost. It is clear that this is a problem facing with not only Mongolians, but also with the people around the world. That's why it is essential to every country to widen and to develop their own special characteristics and to provide every citizen with ecological education in proper and systematic ways. In this article, we aimed to study traditional Mongolian ways of keeping nature, its usage and innovation, and tried to define further tendencies and methods based on the ecological knowledge and educational levels of the youth who are the vital betterment of the society.

Түлхүүр үг

ecological education, young generation, consumption, natural balance, role, responsibility, method